

МОНГОЛ ХҮҮХДИЙН АМАН ХЭВШИЛТ ШҮЛГИЙН ТОГТОЛЦОО**Г.Нандинбилиг, Г.Хонгорзул****Түлхүүр үг:** *Монгол аман зохиол, хүүхэд, шүлэг, аман хэвшилт тогтолцоо*

Хүүхдийн аман зохиолын нэгэн хэлбэр болох аман наадгай нь хүүхдийн сэтгэхүй, хэл ярианы чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн бөгөөд гол төлөв шүлэглэсэн хэлбэртэй байдаг. Хүүхдийн аман шүлгийг академич П.Хорлоо, Х.Сампилдэндэв, эрдэмтэн Г.Ловор, Ц.Оюунбадрах нар цуглуулан эмхтгэж, сурган хүмүүжүүлэх, танин мэдүүлэх ач холбогдол зэрэг олон талаас нь судалсан байх боловч хүүхдийн яруу найргийн уламжлалыг шүлэг зүйн талаас судалсан нь үгүй байна. Иймээс бид энэ удаад хүүхдийн аман яруу найргийн уламжлал дахь аман хэвшилт шүлгийн тогтолцоог судлахыг зорьсон болно.

Монгол шүлгийн тогтолцоо, бүтэц байгууламжийн талаар судлаачдын санал зөрүүтэй байдаг. Анх монголч эрдэмтэн Б.Я.Владимирцов монгол хэлэнд хүчлэг өргөлт голлож байгааг анхааран үзээд “Халхчуудын уянгын дуу нь голцуу жигд өргөлттэй, өргөлтөт шүлгийн зарчмаар зохиогдох ба тэгэхдээ гурав, дөрөв, тав, долоон өргөлттэй шүлэг тохиолддог” гэж үзсэн ба академич Ц.Дамдинсүрэн бээр энэ саналыг дэмжин “Монгол хэлний үг бүрд нэг өргөлт эгшиг бий тул шүлгийн мөрт хэчнээн үг байвал төчнөөн өргөлтөт эгшиг байна. Үүн дээрээс шүлэгт өргөлтөт эгшигийн тоог тэгшитгэх, үгийн тоог тэгшитгэх хоёр уг дүндээ очиж нэг утгатай үгс болно. Иймд монгол шүлгийн үндсэн журам нь мөр бүрийн дотор орсон үгийн тоо тэнцүү байх явдал гэж үзэх үндэстэй юм” (Дамдинсүрэн, 1958:23) гэжээ. Мөн Ч.Чимид (1968), Н.Жамбалсүрэн (1956), М.Гаадамба (1956), Д.Цэнд (1979) нарын судлаачид монгол шүлгийн байгууламжийн өргөлтөт шинж болон шүлгийн адил тоотой байх зарчмыг дэмжин “Монгол шүлгийн хэмнэлийн үндсэн нэгж бол үг” гэж үзжээ. Харин академич Б.Ринчен, Д.Цэрэнсодном нарын эрдэмтэн монгол шүлгийн байгууламжийг үет шүлэг хэмээн үзсэн байна. Академич Б.Ринчен “Монгол шүлгийн бүтцийн хувьд үет шүлгийг тогтолцоо буюу шад тутамд үеийн тоог тогтмол болгон зохиосон тогтолцоо бүхий шүлэг байна... Урт богино эгшигийн байдлаар зохиосон (уртатгалын) шүлэг байна... Монгол хэлнээ өргөлт голцуу эхэн үед буйн учир өргөлтийг голлосон өргөлтөт шүлгийн зүйл арвин үзэгдэж байна” (1970:65) хэмээн бичээд монгол шүлгийн боломж хязгааргүй бөгөөд европын шүлэг зохиох тогтолцоонд нэгтгэж байна хэмээн үзжээ. Мөн академич Д.Цэрэнсодном “Монгол шүлгийн ялангуяа хувьсгалын өмнөх үеийн шүлгийн тогтолцоо бол шад бүхэнд адил тоотой байхыг хатуу шаарддаг үет шүлэг мөн. Тухайлбал, Чойжи-Одсэрийн шүлгийн хэмжээг ажиглахад шүлэг тус бүрийн мөр тутмын үеийн тоог ямар нэг тодорхой хэмжээн чандлан тохируулах эрмэлзэл илэрхий байна” (1977:45) гэж тэмдэглэсэн ба мөн шүлгийг орчин цагийн монгол хэлний дуудлага бичвэрээр бус, монгол бичгийн дуудлагыг баримталж үеийн тоог тодорхойлсон байна.

А.М.Позднеев нарын зарим судлаачид Монголын яруу найрагт ер тодорхой жигд хэмжээ байхгүй гэж үзэж байсан ба Оросын эрдэмтэн Л.К.Герасимович “Европын шүлгийн аль нэгэн байгууламжид байдаг зүй тогтлыг монгол шүлэг зохиох, эрж хайх замаар тогтолцоог

тодорхойлох гэсэн эрмэлзэл үр дүнгээ өгсөнгүй учраас дүгнэлтүүд өөр хоорондоо зөрөөтэй байна” (1987: 20) гээд монгол шүлгийн хэмнэлийн бүтцийг тодорхойлохын тулд туршилт авиа зүйн арга туршилтыг ашиглаж үүний үндсэн дээр монгол шүлэг зохиох талаар зарим маргаантай асуудлыг авч үзэхийг эрмэлзжээ. Тэрээр “Аливаа хэлний авиа зүйн шинж тэмдэгт өргөлт шиг тийм чухал үүрэг бүхий зүйлийг тодруулахгүй аваас монголын шүлгийн асуудлыг шийдвэрлэх боломжгүй. Монголын олон эрдэмтэд өргөлтгүй үетэй эсрэгцэлдсэн өргөлттэй үеийг хэмнэл үүсгэгч гол хэрэглүүр гэж онцлон монгол шүлгийн тогтолцоог өргөлттөт гэж тодорхойлж байна. Гэвч энэ санааг юуны өмнө туршилтын аргаар батлах ёстой. Авиа зүйн туршилтын аргаар олж авсан баримтаар дараах дүгнэлт хийх үндэстэй байна. Үүнд: нэгд, Монгол хэлэнд эхний үед *байнга ногдох* хүчлэг өргөлт байхгүй, хоёрт, үгэнд үеийг тодорхой ялгаруулахуйц уул хэлээр хэлэлцэгчийн сонсголд илэрхий онцгой өргөлт монгол хэлэнд байхгүй хэмээн судалгааны энэ шатанд баталж болох байна. Богино эгшиг нэг урт буюу хос эгшигтэй хосолж байгаа тийм үгэнд урт буюу хос эгшигийг уул хэлээр хэлэлцэгчид мадаггүй тод мэдэж байгаа юм. Хэрвээ үгэнд нэгээс илүү урт (хос) эгшиг байвал осциллограмм ч сонсголын судалгаа ч өргөлттэй эгшигийг илрүүлж чадахгүй” (Герасимович, 1987:24) хэмээжээ. Дээрх дүгнэлтэд “Монгол хэлэнд эхний үед *байнга ногдох* хүчлэг өргөлт байхгүй” гэсний учир нь монгол хэлний эхний үеийн өргөлттөт үеийн богино эгшиг балархайших тохиолдол байдаг. Жишээ нь: “Хазаараа аваад ир” хэмээн хэлэхэд “*Хазаараа ваад ир*” болж үгийн хоёр буюу гуравдугаар үед урт хос эгшиг байгаа тохиолдолд дараагийн үгийн нэгдүгээр үед хүчлэг өргөлт байхгүй болж байгааг хэлжээ. Хоёр дахь дүгнэлтийн хувьд “ааруул, уулаар” гэх мэт үгсийн аль нь өргөлттэй болохыг тодорхойлох аргагүй гэсэн үг юм. Академич Ц.Дамдинсүрэн “Монгол хэлний үгийн өргөлт тэргүүн үедээ байна” гэж үзэж байсан боловч А.С.Пушкины “Олег цэцний дуулал” зохиолыг орчуулахдаа урт ба хос эгшигийг шүлгийн айзамд хэрэглэх талаар гурван зүйл журмыг баримталж байсан нь дээрх дүгнэлттэй үндсэндээ нийцэж байна.

1. Мөрний дунд өргөлттэй эгшгийн завсарт хоёр урт ба хос эгшиг оруулахыг цээрлэжээ.
2. Мөрийн эцэст өргөлттэй эгшгийн дараа урт ба хос эгшиг оруулахыг эрмэлзжээ. Жишээ нь.

Хайртай дуртай мөрийг

Харамж шанд нь аваарай

3. Мөрийн дундах урт ба хос эгшигийг холбож хэрэглэжээ. Жишээ нь

Олег цэцэн ноёнтог

Олон баатраа дагуулан

Тэнэг муусайн Хозарын

Тэрслэн дайрсны хариуд ... гэх мэт (Дамдинсүрэн, 1970:23)

Дээрх гурван журмын эхний журам нь мөрийн дундах үгийн сүүлчийн урт эгшгийн нөлөөгөөр дараагийн үгийн нэгдүгээр үеийн өргөлттөт эгшиг балархайшихаас болгоомжлохын сацуу мөр сунжрахаас сэргийлсэн хэрэг юм. Хэрвээ

“Тэнэг муусайн Хозарын

Тэрслэн дайрсныхаа хариуд”

хэмээвэл мөр сунжирч хэмнэл алдагдаж байна. Ийнхүү үгийн тоо хэдий тэнцүү ч гэсэн урт эгшгийн нөлөөгөөр мөр сунжирч шүлгийн хэмнэлд нөлөөлж байгаа нь Ц.Дамдинсүрэн, Ч.Чимид болон бусад эрдэмтэд “монгол шүлгийн байгууламжийн үндсэн хэрэглүүр бол шад бүрд үгийн тоо тэгш байх явдал бөгөөд “Үг-өлмий” бол хэмнэлийн үндсэн нэгж” (Чимид, 1968:86) хэмээснийг үгүйсгэж байна.

Л.К.Герасимович энэ талаар “Монгол шүлэгт сонсголд өртөхүйц хүчтэй, тод өргөлт байхгүй байгаа нь түүнд өргөлтийн систем байх боломжгүйг үзүүлж буй хэрэг. Гэхдээ монгол шүлэгт, ялангуяа аман зохиолд шадын үгийн тоог тэгшитгэх хандлага маргаангүй гарч байсан бололтой. Тэгэхдээ ямар ч байлаа гэсэн үгийн олон цөөн нь монгол шүлгийн зохион байгуулалтын учир шалтгаан биш, учир нь хэмнэл бол өгүүлбэр зүйгээс хамаарах ямар нэг учир холбогдолтой юм. Үгийн тэгш биш байдал нь шүлгийн хэмнэлийг буй болгох ба бүх эрдэмтдийн учирлан дурдаж байгаа **өгүүлбэр зүйн эн зэрэгцүүлэл** бол монгол шүлгийн хэмнэлийн бүтцийг тодорхойлж шүлгийн шаданд үгийн тоог тэгшитгэх баримжааг бий болгожээ. Монгол шүлэг ба шүлгийн мөр бол өгүүлбэр ба өгүүлбэрийн гишүүдтэй нягт барилдлагатай юм. Тэгшитгэсэн шадуудад үгийн тоо тэгш байлгах гэсэн эрмэлзэл чухам үүнээс үүджээ” (1987:25) хэмээн монгол шүлгийн тэгш бус үгтэй шадууд хэмнэл үүсгэж чадах ба тэгш шадуудын эн зэрэгцүүлэлтэй холбогдол бүхий учрыг үндэслэлтэйгээр тайлбарласан байна.

Монгол аман наадгайн шүлэгт үеийн тоо болон өргөлтийн тоог тэнцүүлсэн шүлэг аль аль ньарвин тохиолдож байна. Харин бидний авч үзэж буй хүүхдийн аман наадгайн шүлэг нь шууд үзүүлбэр тоглолт бус бичигт буулгасан хэлбэр тул орчин цагийн монгол хэлний бичвэрийг баримтлан үед хувааж үзвээс

Хул-сан гэ-рий минь

Хэм-хэр-тэл шөр-гөө-гөөд

Бү-рий бол-тол бай-хаар нь

Баг(а) хут-гаа-раа а-лаад

Их хут-гаа-раа өв-чөөд (Оюунбадрах, 2007:123)

гэхчлэн нэг мөрөнд 5-6 үеэр айзам хэмнэл тэнцүүлэн төгсгөлийн үеүдийг урт эгшгээр өргөсөн байна. Энэ мэтчилэн мөрөн дэх үеийн тоог тэнцүүлэн шүлэглэсэн аман наадгайн жишээ нэлээд байна.

Аман наадгайн шүлэгт дээр дурдсан үгийн тоо болон үеийн тоо тэнцүүлсэн шүлэг арвин байгаа хэдий ч үг болон үеийн тоо алийг нь ч тэнцүүлээгүй шүлгүүд ч мөн тохиолдож байна. Тухайлбал: “Ес хэлэлцэх үг”-ийн

Нэг есөд яах вэ?

Нэрмэл архи хөлдөнө.

Хоёр есөд яах вэ?

Хорз архи хөлдөнө.

Гурван есөд яах вэ?

Гунан үхрийн эвэр хөлдөнө.

Дөрвөн есөд яах вэ?

Дөнөн үхрийн эвэр хуга хөлдөнө (Өлзийхутаг, 1983:31)

гэхчлэн өрнөх харилцаа шүлэглэлдүг болон үеийн тоог тэнцүүлээгүй байна.

Эрдэмтэн Герасимович дээр дурдсан авиа зүйн туршилтын судалгааныхаа талаар “Монгол шүлгийн хэмнэлийн шинж төрхийн судалгааны арга бол, янз бүрийн яруу найрагчдын бичсэн төрөл зүйл, хэмнэлийн бүтцээр ялгаатай 112 шүлгийг техникийн зохих аргаар бичиж авсан юм. Шүлгийг мэргэжлийн уншигчид биш, харин өөр өөр мэргэжлийн янз бүрийн насны таван хүн уншсан. Өөр өөр байрлалд байгаа эгшгийн эрчим чадал, үндсэн өнгө аяын өндөр нам, бүх шүлгийн эгшиг, үе, үгийн уртсах байдлыг (10 м/сек хүртэл нарийвчлан) хэмжих зэргээр осциллограммаар авсан мэдээ баримтыг харьцуулан үзэж нэгтгэн дүгнэж үзлээ. Шад бүрийг дуудахад зайлшгүй шаардагдах хугацааг хэмжихэд харилцан тэнцүү шад шүлгийн цагийн

балансын 93 хувь нь тэнцүү болох нь илэрчээ. Энэ бол монгол шүлэг зохиох тогтолцоонд шүлгийн адил дуудагдах ёс бол хэмнэл үүсгэгч үндсэн нэгжийн нэг болно гэсэн дүгнэлт хийх бүрэн үндэслэлийг бий болгож байна. Монгол шүлгийн туршилт судалгааг дүгнэхэд:

1. Орчин үеийн монгол шүлэг бол шинж төрхөөрөө тооны (квантатив) учир холбогдолтой.
2. Түүний хэмнэлийн гол тодорхойлогч бол
 - А. Шүлгийн адил хугацаанд дуудагдах ёс
 - Б. Шаданд байгаа үеүдийг дуудах харьцаа ба тоогоор зохицуулагдсан синтагмд хуваагдах байдал
 - В. Харьцуулж байгаа шадын өгүүлбэр зүйн ба утгын эн зэрэгцүүлэл
 - Г. Шүлгийн шадын харьцангуй тэгш ба тэгш бус байдал
 - Д. Авианы давталт (Герасимович, 1987:26)

хэмээн дүгнэжээ. Энэ судалгаанд орчин үеийн яруу найрагчдын шүлгүүдийг судалгааны эх хэрэглэгдэхүүн болгосон болно. Харин монгол аман туульсын шүлгийн тогтолцоог судалсан БНХАУ-ын эрдэмтэн Б.Цогжин бээр Яримпилын хайлсан туулийн мөрд байгаа үгийн тоо өөр өөр, үүнээс болж зарим мөр нь урт, зарим нь богино, ийм тэгш бус мөрүүд солбицсон байдалтай байгаа нь ...туульчид өөрийн санаснаараа чөлөөтэй хайлж хэлэх бололцоог олгодог буюу нэгэн хашигдмал загвар, тодорхой хууль журамд үл захирагдан туурвих боломж өгч байгаа юм. Гэвч үүнийг хайлах, түүнийг сонсох үед энэ бадаг нь айзам хэмнэлийн хувьд жигд, тэгш маш уянгалаг, хөгжимлөг сэтгэгдлийг төрүүлдэг. Туульч маань хайлахдаа “*nige ama-yin üge*” (нэг амын үг) гэсэн хэллэгийг байнга хэлж байсан ба энэ нь тоглолтынх нь үндсэн нэгж буюу шүлгийн нэг мөр байжээ. Тэгэхэертуулийн нэг мөр бүр нь туульч Яримпилынхаар бол “нэг амын үг” байх ба нэгэн үлгэр туулийг бүрэлдүүлэх нэгж нь болж байдаг ажээ. Нөгөө талаар энэ нь иж бүрэн аман хэвшил тогтолцоот дүрслэл юм” (Цогжин, 2010:224) хэмээсэн байна. Эндээс үзэхэд “нэг амын үг” хэмээх нь эрдэмтэн Л.К.Герасимовичийн судалгааны “Шүлгийн адил хугацаанд дуудагдах ёс” хэмээхтэй нэгэн ойлголт бөгөөд шад бүрийг аялгуулан хэлэхдээ үгийн олон цөөнийг эс хамааран адил цагтнэг амьсгаанд багтаан дуудаж буйгаа “нэг амын үг” хэмээж байгаа бололтой. Тэрээр цааш нь тодорхойлохдоо “Жангарын туулийн эл эхэд бичгийн зохиол, ялангуяа шүлэг яруу найргийн бүтээлд олонтаа үзэгддэг “мөр сундлах” үзэгдэл байдаггүй. Нэг санааг нэг мөрөөр бүтэн илэрхийлж болдог, бас дараагийнхаа хэдэн мөрийг дамжиж байж сая утга санаагаа бүрэн илэрхийлж болдог. Гэхдээ ийм олон мөрийг дамжлаа гээд дундаа мөр алгасан дараачийн мөрд очдоггүй. Иймээс “Хэлэн байв” мэт хоёр мөрийг туульч чадахын хэрээр аяа урт болгож, холбоцын дутагдлаа нөхдөг ба айзам хэмнэлээ тааруулах үүднээс дараагийн мөрөөс үг авч хэлдэггүй. Ингэж цөөн үг бүхий мөр болон айзам хэмнэл тэгш, цогц үг бүхий мөр хоёрын хооронд огтхон ч ялгаагүй адил байх үзэгдлийг монгол аман шүлгийн үндсэн онцлог гэж үзэж болно” (Цогжин, 2010:271) хэмээсэн нь дээрх хоёр ойлголтыг үндсэндээ ижилхэн гэдгийг баталж байна.

Монгол хүүхдийн “Цагаан тэмээ” тоглоомын

Чагт, ногт, буйл, бурантаг

Гозон бөхтэй

Хүрзэн тавхайтай

Араг араг унгастай

Аяга аяга чөмөгтэй

Эзэн хааны цагаан тэмээг тавья (Хорлоо, 2007:127)

гэсэн шүлгийн эхний мөрийг хэлээд дараагийн мөрөөс эхлэн аялгуулан, шад бүрийг хэлэх хугацаа аль болох ижил байхаар тохируулан хэлэхэд хэмнэлийн зөрөөтэй байдал гарахгүй юм.

Харин тууль бол удаан хугацааны турш тууль хайлах уламжлалын хүрээнд залгамжлагдсаар ирдэг тул дийлэнхдээ тэгш шадуудтай бөгөөд иймэрхүү сондгой байгаа цөөн эсхүл олон үгтэй шадууд нь ихэвчлэн “аман хэвшил тогтолцоот дүрслэл” байдаг ажээ. Б.Цогжин бээр аман хэвшил тогтолцоог тодорхойлохдоо “Дан ганц үг нь шүлгийн мөр, утгат хэлхэцийг бүрдүүлдэг хамгийн бага нэгж биш, харин нэг хэсэг тогтсон хэллэг буюу дахин хуваагдаж үл болох хэлхэц ба холбоо үг нь сая хамгийн бага, хамгийн анхны үндсэн нэгж болдог байна. Ийм нэгжүүд нь маш тогтвортой, бас өөрийнхөө тогтолцоог бүрдүүлдэг. Үүнийг аман хэвшил тогтолцоо гэнэ” (2010: 119) гэжээ. Тухайлбал Яримпилын хайлдаг Жангарын туульд “Алдар ноён Жангар”, “Хүний Начин Хүнд гарт Савар”, “Асар улаан Хонгор” зэрэг чимэг тодотголт хүний нэрс, “хэлэн байв”, “хүнгэнэн хэлэв” гэх энгийн үгсээс эхлээд

Мөнхийн рашаанаас

Рашаанлуулаад

Билгийн рашаанаас

Гар нүүрийг угаалгаад (Цогжин, 2010:216)

гэхчлэн бүтэн тогтсон дүрслэл хүртэл олон дахин давтагддаг аман хэвшил тогтолцоо болдог байна. “Ардын авьяастан туульч болох эхэн үедээ уламжлалт тогтсон хэллэг, дүрслэлийг сайн сурч цээжлэн тогтоож, хайлах үедээ хэрэглэх, ашиглах дадлага сургууль хийж улмаар энэ аргаар тоглолтоо гүйцээдэг нь аман туулийн онцлог мөн бөгөөд энд л аман тууль болон бичгийн зохиолын ялгаа гарч ирнэ” (Цогжин, 2010:272) гэж аман хэвшил шүлгийн тогтолцооны онцлогийг тодорхойлсон байна.

Үүнтэй нэгэн адилаар хүүхдүүд тоглож наадан шүлэглэхдээ эхэндээ бэлэн ардын аман зохиол, зүйр цэцэн үг, жороо үг, аман яриа хоршиж, холбон хэлэлцдэг. Тухайлбал: “Дунд хуруу олох” тоглоомын нэгэн хувилбарт

Гадас хаа байна?

Газар доогуур орсон.

Хэзээ гаргаж өгөх вэ?

Тэхийн эврийг тэнгэрт тулахад

Тэмээн сүүлийг газарт хүрэхэд гаргаж өгнө (Ловор, 1975:104)

хэмээн тогтвортой хэлц үг ашигласан байна.

Хүүхдийн уран зохиол судлаач Д.Оюунбадрах “Хомхой хуруу барих” тоглоомын үг хэллэгийг судлахдаа “Хамгийн сонирхолтой нь гэвэл эхний хүний хариултын сүүлчийн үгийг хоёр дахь хүн асуултынхаа эхэнд давтаад түүнээс ургуулан шинэ санаа гаргаж ирж буйд байна. Энэ бол мөнөөх жороо үгийг бүтээх зарчим юм. Түүнчлэн энэ мэтгэлцээнд

- Чи чинь хусан мод хэвтэй яасан хэдэр юм бэ?

- Хусан мод хэнд муу болсон юм бэ

зэрэг хэллэг байгаа нь жороо үгэнд

Хээрийн хус мод

Модны монгол уяа

гэх мэтээр хэлдгийг санагдуулж байна. Жороо үгийг зүгээр ч нэг утгагүй хэлүүлдэг бус хожим тодорхой утга санаа бүхий өөр зүйл зохиохын бэлтгэл болгодог нь бас батлагдаж байна” (2007, 128) хэмээн өгүүлсэн нь монголчуудын хүүхдийн нас насанд нь тохируулан аман хэвшил тогтолцоондоо сургах дэгийн нэгэн илрэл болж хүүхэд шүлэг холбож хэлэхдээ цээжилсэн, өөрийн мэдэх аман зохиолын үг хэллэг, хэлбэр, зарчмыг дуурайж суралцдагийг хэлсэн байна.

Хүүхэд аливаа зүйлийг цээжлэн тогтоосон байна гэдэг тухайн зүйлийн олон давтагдах түгээмэл чанар эсвэл хэлэхүйд ойр шинжийн илрэл гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл хүүхдийн аман наадгайн шүлэг дэх аман зохиол, аман ярианы үг хэллэг, мөрүүдэд дээр дурдсан туулийн дүрслэлийн нэгэн адил маш тогтвортой, түгээмэл шинж бүхий аман хэвшил тогтолцоо байна.

Судлаач Б.Цогжин монгол туулийн шүлэг яруу найргийн аман хэвшил тогтолцоог судалж, шүлгийн мөрийн байдлыг үндэслээд, бичил аман хэвшил тогтолцоо, бүрэн буюу цогц аман хэвшил тогтолцоо, зэрэгцсэн аман хэвшил тогтолцоо, нийлмэл буюу олон мөр бүхий аман хэвшил тогтолцоо гэж ялгаж үзсэн бөгөөд хэрэглээний шинж чанараар нь

- Тусгай (Зөвхөн тодорхой зориулалт бүхий зүйл дээрээ л хэрэглэгддэг. Алдар ноён Жангар, Хүнд гартай Савар гэх мэтийн тодотголыг өөр баатарт шилжүүлэх боломжгүй)
- Нийтийн (Ухагдахууныг илтгэсэн найруулгын талын дүрслэл юм. Жишээ нь Нүдэндээ цогтой, нүүртээ галтай гэвэл ардын аман зохиол, туульд түгээмэл хэрэглэгддэг) (Цогжин, 2010:206) хэмээн ангилжээ.Тэгэхээр хүүхдийн аман наадгайн шүлгийн аман хэвшил тогтолцоо нь ардын аман зохиолд түгээмэл давтагддаг буюу нийтийн шинжтэй бөгөөд аман яруу найргийн богино төрөл зүйл болохынхоо хувьд ихэвчлэн **бичил аман хэвшил тогтолцоонд** суурилсан болно. Тухайлбал “Ес хэлэлцэх үг”-нд

Нэг есөд яах вэ?

Нэрмэл архи хөлдөнө.

Хоёр есөд яах вэ?

Хорз архи хөлдөнө.

Гурван есөд яах вэ?

Гунан үхрийн эвэр хөлдөнө.

Дөрвөн есөд яах вэ?

Донон үхрийн эвэр хуга хөлдөнө...

хэмээн “нэрмэл - нэг, хоёр - хорз, гуна - гурав, дөрөв - дөнө” зэрэг нь хамт хэрэглэж хэвшсэн тогтсон үг хэллэг болно. Жангарын туульд:

...Хүний Начин

Хүнд гартай савар гэдэг

Гуна ордог насанд нь

Ээж нь өнгөрсөн

Дөнө ордог насанд нь

Аав нь өнгөрсөн... (Цогжин, 2010:258)

хэмээн дүрсэлдэг бол “**Турван настай гунан** улаан баатар (МАБТ, 1982:50)” нэртэй тууль ч бас байна. Мөн монголчууд

Архийг нэрвэл арз

Арзыг нэрвэл хорз

Хорзыг нэрвэл хор

гэхчлэн хэлэлцдэг нь эдгээр үгсийн давтагдах шинжийг илтгэж байгаа бөгөөд дээрх “Ес хэлэлцэх үг” бичил аман хэвшил тогтолцооны цогцоос бүрдсэн болно. Түүнчлэн “нэрмэл-хорз, гуна-дөнө” хэмээн тогтвортой ахиулсан аман хэвшил дүрслэл ч мөн ажиглагдаж байна.

Дээр дурдсан тогтвортой хэлц үгсийг шүлэглэхдээ ашигласан жишээ ч мэр сэр байх бөгөөд энэ нь **зэрэгцсэн аман хэвшил тогтолцоо** болох юм. Тухайлбал: “Цагаан ямаа арлуулах” тоглоомд

Цэцэн нь цээжинд

Цэцэг нь ууланд

Таавар нь тархинд

Таавал авцгаа! (Ловор, 2007:36)

хэмээсэн нь монгол аман зохиолд түгээмэл тохиолдох

Цэцэн үг цээжинд

Цэцэг навч ууланд

гэсэн аман хэвшилт шүлгийн тогтолцоог хураан ашиглажээ. Эндээс хүүхдийн аман наадгайн үг хэллэгт ч бас хэлний хэмнэх зарчим үйлчилж байгаа нь ажиглагдаж байна.

Хүүхдүүд энэ мэтчлэн ардын аман зохиолын төрөл зүйлсээс суралцахаас гадна шүлэг зохиох айзам тэнцүүлэхдээ ярианы хэлэнд түгээмэл тохиолдох авиа сэлгэх зарчмыг ашигладаг нь мөн л аман хэвшил тогтолцооны илрэл юм. Тухайлбал:

Хэн булхайдав, хэлж өг

Хэлмэн, Жулман

Дээлий, Мээлий

Дэвчин, Гувчин

Хорголоо, Морголоо

Могодгос (Ловор, 2007:69)

хэмээх шодох үгэнд эхний гийгүүлэгчийг “м” авиагаар сэлгэн утга тодорхойгүй үг хоршуулан үүсгэж, хоёроос гурван үетэй үгсээр сүүл холбон айзам хэмнэл тааруулжээ. Ийнхүү хүүхдүүд тоглож наадан шүлэглэх нэг арга аман хэвшил тогтолцоот үг хэллэг, хэлц тэргүүтнийг ашиглах арга бөгөөд ингэхдээ тухайн шүлгийн үг үеийн тоог бодох бус харин хүмүүсийн яриа, сонсож мэдсэн үлгэр, зүйр үг, жороо үг зэрэгт хэрхэн шүлэглэж, үг хэллэгийг хэрхэн холбож хэлэлцдэгийг бодолцон, шүлгийн шатаа бүтээдэг байна. Харин эдгээрт суралцах явцдаа мөн өөрсдөө **шинээр үг хэллэг зохион** шүлэгтээ ашиглах нь ч буй. Ийнхүү шинээр үг бүтээхэд монгол хэлээр хэлд орж, аман зохиолын яруу сайхныг сонсож, ойлгож ухаарсан хүүхэд болоод түүний хэлний мэдрэмж гэгч хамгаас чухал нөлөөтэй. Чухам энэ шинжээрээ бусад шүлэг, яруу найргаас ялгарна. Эрдэмтэн Г.Ловор “Онъсогод юмс үзэгдлийн нэрийг нууцлан өөр зүйлээр төлөөлүүлэхдээ ихэвчлэн шинэ үг бүтээж хэрэглэдэг” (МАОТ, 1990:18) гэсэн бол хүүхдийн аман наадгайн шүлэгт айзам хэмнэл тэнцүүлэх үүрэгтэйгээр утга тодорхой болон тодорхой бус шинэ үг зохион хэрэглэдэг байна. Аман наадгайн шүлэг дэх зохиомол үгс нь ихэвчлэн мөр хоорондын болон мөрийн дотор толгой холбох үед үүсдэг байна.

Утга тодорхой зохиомол үгсээр айзам хэмнэл тэнцүүлсэн аман наадгайн жишээнээс дурдвал:

Хэлвэн зэлвэн

Гахал гувчуур

Эргэлдэй хорголдой

Холтос хэлтэс (Ловор, 2007:69)

хэмээх шодох үгэнд “хэлвэн”, “зэлвэн” гэх мэт зохиомол үгс, мөн “эргэлд-эй”, “хоргол-дой” хэмээн утга тодорхой нэр ба үйл үгнээс дагаврын аргаар шинэ үг бүтээн хэрэглэсэн байна. Энд хүүхэд үүсмэл үгс ямар аргаар бүтдэгийг ажиглан түүнийгээ өөр жишээнд хэрэглэн турших оролдлого хийсэн мэт санагдаж байна. Мөн цаашилбал

Алаг даага ад гээд

Аав намайг өгнө гээд

Эрээн шувуу эд гээд

Ээж бас өгнө гээд

Бялзуухай бид гээд

Би бас гарна гээд

Хөхөө шувуу хөд гээд

Хүргэн намайг авна гээд

Шаазгай шаг гээд

Шахаа бас бүтнэ гэж байна.

Бүвгэлдэй шувуу бөө гээд

Бүгд явдал бүтнэ гэж байна (Ловор, 2007:32)

гэх зугаа үгэнд “ад, эд, хөд, бөв” гэх авиа дуурайх болон дүрслэх утгатай зохиомол үгс үүсгэн мөрийн эхний үгтэй толгой холбож байна. Энд буй “ад” хэмээх үгийн утгыг мөшгөж үзвэл “ад тотгор, ад зэтгэр, ад хорлол” хэмээсэн үгсээс гадна атаа жөтөө хэмээх үгийн утга ч бас буй бололтой. *а-та-га* (атаа - хоёр юм сөргөлдөх, бусдын сайнд мөчөөрхөх сэтгэл) хэмээх үг нь а-д-ку-ку- (атгах - хавчих хамжих) хэмээх үгээс үүсч, улмаар а-д-ка-г (атгаг - сэжиг, хорсол – атаархсанаас муу хор буцлах) гэсэн үг бүтсэн байна. Эрдэмтэн Д.Цэрэнсодном *ад тотгор* хэмээх үгийн “ад” гэдгийг самгарьд хэлний *а-та* ‘хорт санаа, хорт бодлого’, төвд хэлний ‘хөнөөл уршиг’ гэсэн үгээс гарсан бололтой” гэж үзсэн. Энэ үгийг К.Голстунский “а-да ‘ад гэм’ (унадаг өвчин), а-да ‘чөтгөр’ гэдэг үгийг толгойлоод “д” нь а-да-хаг, жэ-дэ-гэ/ү-р (зэтгэр, гай тотгор), жэ-дэ-гэ/ү-кү /зэтгэх-хорих, хатгах, сөрөх/ то-д-кар, тү-йи-д-кэр зэрэг үгнээ байх шиг санагдана. Явж явж “сэ-д-гэ-кү, жэ-д-гэ-кү, а-да, а-д-каг, то-д-ка-р, ка-д-ку-ку” зэрэг үгс нь “сэр хийх, сэд хийх, хар хийх, хад хийх” зэрэг авиа дуурайх үгнээс эхтэй (1995: 193) хэмээн М.Базаррагчаа үзжээ. Монгол домог зүйд “ад” гэсэн ойлголтыг “Хүүхэд нялхсын өвчин эмгэгийг түгээн явагч хий биетан. Үдшийн бүрий, шөнийн харанхуйгаар элдэв дүрс хэлбэрт хувилан бага нялхсыг айлган хөлсүүлэх юм уу адайр зантай болгодог гэдэг. Адатсан хүүхдийг домнохдоо галд тугалга хайлуулж хүйтэн цэвэр устай аяганд цутган царцаагаад гарсан дүрсийг шинжин домнодог” (Дулам, 1989:160) хэмээн үздэгтэй ч бас тодорхой сэжмээр холбоотой. Энэ мэтээс үзэхэд “ад” нь атаа жөтөө, ад зэтгэр, ад хорлол ч бай дараагийн мөрний “аав” хэмээх үгтэй холбогдож байгаа бөгөөд аавын “ад”-тай хамаарал бүхий эндэл хүүхдээсээ салахад ч хүргэж болзошгүй гэсэн утга буй.

Хүснэгт 1

№	Амьтан (бэлгэдлийн тайлбар)	Авиа дуурайх үгс (гарал, утгын тайлбар)	Хам сэдвийн тайлбар
1	Алаг даага– Домогт Эрхий мэргэний унаа байсан ч “Хараацайг гүйцнэ” гэсэн амандаа хүрээгүйн тул урд хоёр хөлөө тайруулан газар доогуур амьдрах болсон.	“Ад тотгор,” хэмээх үгийн “ад” гэдгийг самгарьд хэлний “а-та /хорт санаа, хорт бодлого/”, төвд хэлний “хөнөөл уршиг” гэсэн үгнээс гарсан бололтой” Мөн “сэ-д-гэ-кү, жэ-д-гэ-кү, а-да, а-д-каг, то-д-ка-р, ка-д-ку-ку” зэрэг үгс нь “сэр хийх, сэд хийх, хар хийх, хад хийх” зэрэг авиа дуурайх үгнээс эхтэй”	“Аав намайг өгнө гээд” гэсэн нь аавын алдаа эндэл буюу хүүхдээсээ хагацах салах нь ад зэтгэрийн хорлолтой холбоотойн зэрэгцээ тэр хүү “ад”-г илтгэж буй амьтан нь эрт цагтаа эрхий мэргэний унаа байсан алагдаага болж байна. Энд амандаа хүрээгүй алаг даага, “ад”-нд автсан эцэг хоёрыг зэрэгцүүлсэн нь тодорхой байна.
2	Эрээн шувуу – Өнгөний бэлгэдэл талаас зүүний дөчин дөрвөн тэнгэр нэрийн нэг нь эрээн өнгө зүстэй гэгддэг. Мөн баатарлаг туульст бор эрээн бялзуухай гэрт орж ирж зүүдлэгдэх нь дайсан ирэхийг зөгнөдөг.	Эд – Үгийн сангийн утга нь эдэлж хэрэглэдэг зүйлийн ерөнхий нэр бөгөөд эд хогшил, эд хөрөнгө, эдийн шунал зэргийг төлөөлсөн утга буй бололтой.	Ээж намайг өгнө гээд: Эрээн шувуу эд гэхэд ээж нь хүүхдээ өгнө гэж байгаа нь чухамдаа ээжийн эндэл нь өнгөний эрээн мяраан, өрөөлийн эд хогшилд шунал дурлахтай л холбоотойг илэрхийлж байна

4	Бялзуухай шувуу – Хаан чингэл баатар хэмээх баатарлаг туульст Хаан чингэл баатрын дүү Урангуа дагина гэрийн хатавч, тогто, өрхөөр бор эрээн бялзуухай орж ирлээ гэж зүүдэлсэн нь дайсан ирж буйн зөн байсан гэж гардаг. Мөн бялзуухай айлын гэрт орвол барьж аваад хатавчинд толгойг хойш харуулан босгон дээр цавчиж муу ёрыг хариулна. ²	Бид – Пид гэх дуу чимээ дуурайх үгийг бялзуухай гэдэг үгтэй толгой холбох зорилгоор дуудлагын төстэй байдлаар нь ийнхүү сэлгэсэн мэт санагдана.	Би бас гарна гээд гэж байгаа нь хүүхдийн ертөнцийн биеэ даах гэсэн сэтгэлгээний нэгэн илрэл байж болох талтай юм. Сэтгэл судлаач Э.Эриксон хүүхэд биеэ даах үеийг /3 орчим нас/ “Би өөрөө” “Би чадна” хэмээдэг үе гэсэн байдаг.
3	Хөхөө шувуу – Өндгөө бусдын үүрэнд орхидог тул үрдээ ачлалгүй эхийг ийн зүйрлэдэг	Хөд - Хөдлөх, хөдөө, хөдийх /годойх хатуурах/ гэх мэт үгийн язгуур ³ бөгөөд хөдөлгөөний үндсэн утгыг илтгэнэ.	Хөхөө шувуу хөд гээд Хүргэн намайг авна гээд: Энэ дүрслэлийн эхний мөр хүргэнтэй бус харин өмнөх мөрний ээжтэй холбогдож буй бололтой. Эдийн эрээн мяраанд шунасан ээжийг хөхөөтэй зүйрлэж, харин хүүхдийг нь хүргэнэргөж асрахын утга байгаа мэт санагдана.
4	Шаазгай шувуу – Сайн муу хэлийг саадгүй түргэн хэлдэг шувуу.	Шаг – шаг дуугарах, шагшрах дуу чимээг дуурайсан үг	Шахаа бас бүтнэ гээд Шахаа – Үгийн сангийн утга нь “бузар муухай юмны доогуур шургуулан ам алдуулах ёс, зэм оноох” гэсэн утгатай. Мөн бөө мөргөлийн яруу найрагт “Эрлэг хаанд сонсгож, эх дэлхийгээр гэрчлүүлэн, андгай тангараг тавьж тэнгэр сахиусанд өргөсөн андгай шахаа шүлэг” гэж байдаг.
5	Бүвгэлдэй шувуу – “Бүв бүв” гэх авиа дуурайх үгнээ нэр үг үүсгэх дагавар залган үүсгэсэн зохиомол нэр бололтой.	Бүв – бүвтнэх, бүвгэнэх зэргийн язгуур, авиа дуурайх үг	“Бүх явдал бүтнэ гэж байна” хэмээснээс үзэхэд бүвгэлдэй хэмээх шувуу нь сайн хэлийг дуулгадаг, эерэг бэлгэдэлтэй бололтой.

Дээрх шүлэгт алаг даага, эрээн шувуу, бялзуухай, шаазгай, бүвгэлдэй зэрэг шувуудын бэлгэдлийг ажиглавал ёрлох утгаар эхлэсэн ч аажим зөөлөрсөн шинжтэй байна. Мөн дээрх амьтдын хүргэсэн хэл чимээ нь ч дээрхтэй нэгэн адил муу мэдээнээс сайн руу эрэмбэлсэн байна. Ийнхүү хам утгыг нэгтгэн үзвэл алаг дааганы тээсэн ад, эрээн шувууны хэлсэн эд хоёроос болж ээж аав нь хүүхдээ өгнө гэхэд хүүхэд ч өөрийн гэрээсээ дайжих санааг илтгэн “Би бас гарна” гэж байна. Энд мөн хөхөө шувуугаар үрдээ ачлалгүй эцэг эхийг төлөөлүүлдэд хүүхдийг нь хүргэн авна гэж байна. Энд гарч буй онцлох нэгэн зүйл бол “Хүргэн намайг авна гээд” хэмээх хэсэг нь “Монголын нууц товчоо”-нд Есүхэй баатар Мэнлигт “Дотор минь муу байна. Өнчин хоцорсон дүү нараа, бэлэвсэн бэргэнээ асрахыг чи мэд. Тэмүжин хөвүүнийг даруй явж авчир. Хайрт Мэнлиг минь хэмээсээр наснаас нөгчив (МНТ, §169)” гэсэн хэсгийг сануулж байгаа бөгөөд эртнээс монголчуудын дунд хэвшсэн “Асрах ёс”-ны нэгэн илрэл мэт санагдана. Монголчуудын дунд эгч дүүс нэг нэгнийхээ хүүхдийг авч, асран өсгөх нь их бий. Тэгэхээр нагац эгчтэй суусан хүнээ хүргэн хэмээнэ. Тиймээс ч дээрх шүлэгт ийнхүү дүрсэлсэн нь “асрах ёс”-той холбоотой байж болох юм. Ийнхүү эцэст нь бүвгэлдэй шувууны “Бүх явдал бүтнэ” гэсэн сайн хэлээр зугаа үг төгсөж байна.

Дээрхээс үзвэл аав, ээжийн ад, эдээс болсон алдаа эндэл хүүхдэд хэрхэн тусдаг гэдгийг бэлгэдэл зүйн нарийн тогтолцоотойгоор ахиулан харуулсан нь хүүхдийн шүлгийн сэтгэлгээ болоод агуулгын гүн гүнзгий чанарыг илтгэж байна. Өнгөц ажиглахад зүгээр л амьтдын нэрийг хөдөлгөөн дуурайсан үгтэй нь хоршуулан толгой холбосон мэт хэрнээ лавшруулан судалж үзмэгц өвөрмөц, гүн гүнзгий бэлгэдэлт утгын танивар дохиог агуулж байна. Мөн “Дунд хуруу олох” хуруу гарын уламжлалт тоглоомын

...Хааны хар нохой ирээд

Дэрс рүү дэлд

Хулс руу хулд гэхихлээ (Гаадамба, Сампилдэндэв, 1978:87)

гэх жишээнд “дэлд” гэдэг үгийн толь бичгийн утга нь “хэнгэрэг дэлдэх” гэсэн үйлийн утгаар байх боловч энд “дэлдэн, дэлдгэс, дэлдийх” зэргийн язгуурыг салган дан үг бүтээсэн бол, түүнтэй ижилсүүлэн “хулс” гэдэг үгийн авиаг давтан зохиосон “хулд” хэмээх үгийг ашигласан байна. Хэдий зохиомол үг боловч огцом түргэн хөдөлгөөний утга илрэн гарч байгаагийн гол шалтгаан нь “дэлдгэс” гэх түргэн хөдөлгөөн дуурайх үгийн язгуурыг ашигласан төдийгүй “хард, ярд” гэх мэт цочмог дуу авиа дуурайсан үгстэй бүтэц, сонсогдох байдлын хувьд ижилсүүлсэнд байна.

Утга тодорхой бус зохиомол үгсээр айзам хэмнэл тэнцүүлсэн өөр нэгэн жишээ гэвэл “Хэцүү” хэмээх хүүхдийн зугаа үлгэрт “...Эмч чи хэцүү юм бол миний хугархай хөлийг эдгээж эль гээжээ. Эмч туулайн хөлийг эдгээгээд ам самдаан жаргажээ” хэмээсний доторх “ам самдаан” хэмээх хэллэгийн утгыг хөөж үзвээс “сам” гэдэг үгийн салаа утга 1. Бөө удган, самын шаашин, сам нь чөтгөр шимнусыг үлдэн хөөж, өвчин эмгэг гай барцдыг засах шившилэг хийнэ 2. Чөлөө учрал 3. Даяан (самд суух) хэмээн тайлбарлажээ. Гэвч эдгээр утгын аль аль нь ам гэдэг үгтэй утгын авцалдаагүй бөгөөд энэ хоршоо үг нь арын “амар сайхандаа” гэдэг үгийн эхний үеэс бүтсэн зохиомол үг болно. “Амар – ам”, “сайхандаа – самдаан” хэмээн хэлэх аялгад нийцүүлэх үүднээс зохиосон шиг байна.

Мөн цаашилбал “Хул тоолох” үгэнд

Яа яа хул

Ясан хул

Ян ян хул

Яндан хул

Дэн дэн хул

Дэрсэн хул

Тон тон хул

Тосон хул

Бөн бөн хул

Бөөрөнхий хул

Гон гон хул

Гурвалжин хул... (Ловор, 2007:39)

гэхчлэн хорин таван хул тоолох үгийн “яа”, “ян”, “дэн”, “дон”, “бөн”, “гон” зэрэг үгс нь дараагийн шадны эхний үгсийн тэргүүн үеийг давтжээ. Энд хүүхэд хэлд орох явцын үзэгдэл ажиглагдаж байна. Энд давтагдаж байгаа үгс болон авиа нь “я”, “н”, “д”, “т” гэх мэт хэлэхэд төвөггүй авианууд байх бөгөөд хүүхэд хэлд орох эхэн үедээ эдгээр авиаг давтан хэлж зөв тодорхой хэлэхэд суралцаад цаашлан хэлэхэд төвөгтэй авиа болох “р, л” зэргийг зөв хэлүүлж сургах зорилго чиглэл бүхий “Арван таван тарган тарлан харлаг сарлагийн таргийг тараг гэж эс уугаад ямар арван таван тарган тарлан харлаг сарлагийн таргийг тараг гэж уух юм бэ” гэдэг түргэн хэллэгийг хэлүүлдэг байна. Аман яруу найргийн өөр нэгэн богино төрөл зүйл болох оньсогот ийм үзэгдэл багагүй үзэгддэг. Ийм оньсогын утга үүргийн талаар эрдэмтэн судлаач Г.Ловор “Уг юмын хэсгийн бүтэц, өнгө зүс, шинж тэмдгээр ижилдүү бол уг зүйлийг хүч нэмэгдүүлэх маягтай утга тодгүй үгээр ахин давтан, тухайлбал хамхуулын тухай оньсогод

Зүү зүү шаргал

Зүс нэг шаргал

Бай бай шаргал

Бас нэг шаргал

Бай бай цагаан

Байдаггүй цагаан

Зүй зүй цагаан

Зүйдэлгүй цагаан

гэхчлэн нэгэн жигд гэсэн санааг гаргах жишээтэй” (2005:118) гэж үзсэн бол зохиомол үгсээр оньсоголох аргыг судалсан залуу судлаач Д.Нямдорж “Оньсоголж буй зүйлийнхээ нэрийн тэргүүн үеийг салган утга тодорхойгүй зохиомол үг үүсгэн оньсоголохоос тухайн оньсогоныхоо хэлэхүйд таацуулан мөрийн эхний үг болоод төгсгөлийн үгийн тэргүүн үеийг салган утга тодорхойгүй зохиомол үг үүсгэн оньсоголж байна.

Жий жий жимбүүхэй

Жинхэнэ бие нь ясгүй

Хай хай хамбуухай

Хамаг бие нь ясгүй

гэсэн ялааны тухай оньсогод “жий жий”, “хай хай” гэж давтсан нь мөр тэнцүүлэх хэмнэл үүсгэхээс гадна тухайн оньсоголж буй зүйл нь жигдхэн олон гэсэн санааг илэрхийлэх бололтой. Гэвч дангаараа үгийн сангийн бодит хийгээд хийсвэр утгын аль алиныг илэрхийлж чадахгүй бөгөөд харин тухайн оньсогогынхоо хам бичвэрт орохоороо хүч нэмэгдүүлэх маягийн утга илтгэх бололтой” (2010:23) гэж үзжээ.

Энэ мэт жишээ баримтаас үзэхэд хүүхдийн аман наадгай дахь зохиомол үгс ньэхийн доторхэмнэл тэнцүүлэх, хүч нэмэгдүүлэх үүрэгтэй болохоос дангаараа утга илэрхийлэхгүй байна.

Дүгнэлт

Хүүхдийн аман яруу найргийн уламжлал дахь аман хэвшилт шүлгийн тогтолцоог авч үзээд бид дараах дүгнэлтийг хийж байна.

1. Хүүхдийн аман наадгайд тохиолдох зарим урт ба богино шадууд нь монгол аман яруу найргийн уламжлалт аман хэвшил тогтолцоотой шууд холбогдож байна.
2. Хүүхдийн аман наадгайн шүлэглэл нь хэл хэллэг, хэлбэр, найруулгын хувьд аман зохиол ба аман ярианд элбэг тохиолдох хэвшмэл холбоо, хоршоо үг хэллэг зэрэг бичил аман хэвшил тогтолцоо болон хэлц, зүйр үг, жороо үг мэтийн зэрэгцсэн аман хэвшил тогтолцоонд суурилж байна.
3. Хүүхдийн аман наадгайн шүлэглэл нь утга тодорхой ба тодорхой бус зохиомол үгсээр айзам хэмнэлээ тэнцүүлэх өвөрмөц онцлогтой ба энэ нь авиа дуурайх үг, дүрслэх үг, үүсмэл үгнээ дагавар залгаж үг бүтээх зарчмаар шинэ үгс үүсгэн, хүүхдийн аман яруу найргийн үгийн санг баяжуулж байна.
4. Энэ мэтчилэн хүүхдийн аман яруу найраг дахь хүүхдийн зохиосон үг хэллэг нь эх хэлний үгийн санг баяжуулан хөгжүүлэхэд хүүхдийн оролцоо багагүй байдгийг илтгэж байна.

Summary

In this paper, the author concludes the analysis on oral formula in Mongolian children oral children's oral poetry and other conversational genres.

Some of the stanzas in children's oral poetry and other conversational genres are smoothly linked to the oral literature system, which has been carried with traditional poetry. Shortened or elongated lines, which occur in children limericks (аман наадгай), relate directly to speaking patterns of the oral poetry, whereas the children limericks (аман наадгай) derive from both: one, oral formula such as collocations and phrases, which are popular in folklore and oral / colloquial language in forms/ perspective of language and expressions; two, parallel oral formula such as proverbs and *joroo* sayings.

The specific feature of the children oral poetry is the balancing of the rhythm by words with direct and implicit meanings, which contributes the lexis of the children oral poetry with creating new words by adding suffixes to onomatopoeic, descriptive and derived words.

Words and expressions, created within children poems, prove that there is lingual intuition among children as well as children interference to the source language vocabulary development and enrichment.

Номзүй

- Бадамдорж Д. Монгол хэлний утга судлал. Нэгдүгээр дэвтэр. Уб., 2001.
- Базаррагчаа М. Монгол үгийн гарлыг мөшгөх нь. Уб., 1995.
- Гаадамба Ш., Цэрэнсодном Д. Монгол ардын аман зохиолын дээж бичиг. Уб., 1978
- Гаадамба Ш. Шүлэг зохиох асуудалд. Туяа сэтгүүл, 1956, №6
- Гантогтох Г. Бөөгийн шахангийн үг хэллэг. МУИС-ийн Эрдэм шинжилгээний бичиг, №14 (151). Уб., 1999
- Герасимович Л.К. Монгол шүлэг зохиох тогтолцооны тухай. Гадаадынхан монголын уран зохиолын тухай, Уб, 1987,
- Дамдинсүрэн Ц. Монгол хэл бичгийн тухай. Уб., 1958
- Дамдинсүрэн Ц. Олег цэцний орчуулгын тайлбар. Монгол хэл бичгийн тухай, Уб., 1970
- Дулам С. Зүүд, зөн совингийн бэлгэдэл зүй, цагийн бэлгэдэл зүй. Уб., 2011.
- Дулам С. Монгол домог зүйн дүр. Уб., 1989.
- Дулам С. Монгол соёл иргэншлийн утга тайлал. Уб., 2013.
- Жамбалсүрэн Н. Монгол шүлэг. Утга зохиол сонин. Уб., 1956, №8.
- Ловор Г. Аман наадгай. Хүүхдийн аман зохиолын дээж. Уб., 2007.
- Ловор Г. Хүүхдийн аман зохиолын тоглоом наадмын үг хэллэг. АЗС. Т-IX. Уб., 1975, х.
- Ловор Г. Монгол оньсогоын уран сайхны онцлог, утга, учир зүй, Уб., 1972.
- Магсаржав Б. XX зууны жараад оны монгол шүлгийн туурвилзүйн зарим онцлог. Уб., 2006.
- МАБТ - Монгол ардын баатарлаг туульс. Уб., 1982.
- МАОТ- Монгол ардын оньсого таавар. Эмх. боловс. Г.Ловор, Ц.Өлзийхутаг. Уб., 1990.
- Нямдорж Д. Монгол аман зохиол дахь зохиомол үгсээр оньсоголох арга. Бакалаврын дипломын ажил. Уб., 2010.
- Оюунбадрах Ц. Монголын хүүхдийн уран зохиол. Уб., 2007.

Өлзийхутаг Ц. Туулай туулай тонгос. УБ., 1970.

Өлзийхутаг Ц. Ерөөл магтаал, зугаа уг-үгэн тоглоом. УБ., 1983.

Ринчен Б. Монгол шүлгийн учир. Хэл зохиол судлал, 7, 8-р боть, УБ, 1970.

Сампилдэндэв Х. Ардын жүжиг наадмын аман зохиол. УБ., 1988.

Сүхбаатар Г. Даригангын хүүхдийн тоглоом. УБ., ШУАХ. 1962.

Хорлоо П. Монгол ардын дууны яруу найраг. УБ., 2007.

Цогжин Б. Монгол аман туулийн шүлэг зүй. УБ., 2010.

Цэнд Д. Монгол шүлгийн тогтолцоо. Монголын уран зохиолын хөгжлийн асуудалд, УБ., 1979.

Цэрэнсодном Д. Монгол шүлгийн онол түүхийн асуудал. УБ., 1977.

Чимид Ч. Монгол шүлгийн тогтолцоо. Үгийн ид шид. УБ., 1968.